

БАРУУН-УРТ СУМЫН 5 ДУГААР САРЫН МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО:

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:Тайлант сарын байдлаар Тамгын газраас 111 бичиг явж, 169 бичиг ирсэн байна.Үүнд:

Хариутай бичиг-17, хугацаандаа явсан-4, хугацаа болоогүй-3 байна.

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрт танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, барагдуулалтад хяналт тавьж ажиллалаа.

Тус Тамгын газар нь албан хэргээ хос бичгээр хөтөлж хэвшсэн.

Байгууллагын даргаас гаргасан 142 шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчилгүй шийдвэр гаргаж хэвшсэн.Үүнд: -Захирамж А/73 -Захирамж Б/11 -Тушаал А/13 - Тушаал Б/45 байна.

“Малын А” дансны лавлагаа авах хүсэлт гаргасан 40 иргэнд лавлагаа гарган өгсөн.

Багийн Засаг даргаас 464 иргэнд тодорхойлолт гаргаж үйлчилсэн.

Төрийн үйлчилгээний оператор төлбөртэй үйлчилгээ-135, төлбөргүй үйлчилгээ-196, цахимаар 78, тоон гарын үсгээр 259, нийт 331 иргэнд лавлагаа тодорхойлолт үйлчилгээ авсан байна.Үүнд:

- 1.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа-78
2. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа-48
3. Иргэний үнэмлэхний лавлагаа-45
4. Оршин суугаа хаягийн бүртгэл-24
5. Шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх лавлагаа-23
6. Жолооны үнэмлэх захилга -12
7. Жолоочийн лавлагаа-12
8. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх -11
9. Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтаар -9
10. Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа-8
11. Гэрэлсний бүргэлийн лавлагаа-8
12. Авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэл-6
13. төрсний бүргэлийн лавлагаа-6
14. Авто тээврийн улсын бүртгэлийн торгууль төлөх-15
15. Зээлийн мэдээлэл -4
16. Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай -4
17. Авто тээврийн улсын бүртгэлийн торгууль төлөх-4
18. Кадастрийн зураг-4
19. Иргэний эрүүгийн хариуцлага байгаа -3
20. Иргэнд олгох тодорхойлолт -2
- 21.Тэтгэвэр тогтооллын хуудас-2
22. Тэтгэвэр тогтооллын хуудас эрх үүсээгүй лавлагаа-2
23. Цагдаагийн ерөнхий гарын төв архивын лавлагаа-2
24. Эрүүл мэндийн даатгалын төлөлтийн лавлагаа-2
25. 13-А маягтын бүртгэл-2
26. Хуулийн этгээд нэр баталгаажуулах хүсэлт -1
27. Газар эзэмших хуулийн этгээд бүртгэл-1
28. Эрүүл мэндийн цаг авах үйлчилгээ -1

Тамгын газраас хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг олон нийтэд мэдээлэх зорилгоор орон нутгийн BBS тв, Сүхбаатарын өнгө сонин, Sb ingo сайт хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 10 удаа мэдээлэл нийтэлсэн.

Багийн Засаг дарга нар нь 460 айл өрхөөр явж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан.

Сумын Засаг даргын 2023 оны А/112 тоот захирамжаар 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага, халалтын ажлыг 76 хүний бүрэлдхүүнтэйгээр 2 өдрийн турш зохион байгууллаа. Баруун-Урт сумын 18-25 насны нийт 470 иргэнд цэргийн жинхэнэ албанд татах зарлан дуудах мэдэгдэл өгч ажилласнаас 192 иргэн эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж Жанжин штабын тогтоосон хяналтын тооны дагуу тэнцсэн цэргүүд Дорнод аймгийн 0132 дугаар ангид хугацаат алба хаахаар хуваарлагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр: Тус Тамгын газраас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран тусгай хэрэгцээт иргэдийг соён гэгээрүүлэх, нийгэмшүүлэх, эрх хөгжил хамгааллыг нь дэмжих зорилготой хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд боловсрол, спорт, соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагатай хамтран "Тэгш боломжийг хамтдаа" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Арга хэмжээнд аймгийн Үйлдвэрчний эвлэл, Гэр бүл сайн сайхны нийгэмлэг, Хөл бөмбөгийн холбоо, Шатрын холбоо, Сийлэнгоо эмэгтэйчүүдийн клуб, Ахмадын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг иргэний нийгэмлэгийн 7 байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй 15 иргэн оролцож ажлын санал солилцон хамтран ажиллах шийдвэрт хүрсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж асаргаа шинээр тогтоолгох 7, асаргаа сунгах 14, асран хамгаалагч солих 2, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асарч байгаа 1 иргэн, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1 иргэн, ОНОТХҮйлчилгээний төсөл хөтөлбөрт 3 бүлгийн төслийг тус тус дэмжиж хамруулаад байна.

Шинэ төрсөн хүүхэд-42, цалинтай эхийн тэтгэмжинд-41, жирэмсэн эхийн тэтгэмжинд -26, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт шинээр орж байгаа болон сунгагдсан-16, утасны хөнгөлөлтөнд 2, ихэр хүүхдийн тэтгэмж 1, оршуулгын тэтгэмжинд 2 иргэн, ахмад настны хөнгөлөлтөнд 39 ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 4 иргэн, ахмад настны амралт, сувилалын эрхийн бичигт 46 ахмад настныг тус тус бүртгэн нөхөн олголтыг бүрэн хийж гүйцэтгэлээ. Хүүхдийн мөнгөтэй холбоотой биеэр ирсэн 4, утсаар 1, цахимаар 5 иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргжн ажилласан.

2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа өрхүүдэд ажил мэргэжилийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх сургалтад 27 иргэн, бичиг баримтаа хаяж гээгдүүлсэн болон захиалж чадахгүй байгаа 5 иргэн, 0-6 настны хүүхдээ гэртээ харж байгаа ажилгүй 9 эмэгтэйг тогоочийн сургалтад тус тус хамруулсан.

Баруун-Урт сумын ахмадын хорооноос 1-р 10 жилийн сургуулийн багш нартай хамтран ахмадуудынхаа дунд “Дэргэдийн бурхадаас суралцъя” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 70 орчим ахмад хүрэлцэн ирж, урилгаар лектор

багш Ц.Цэгмиджав оролцож сонирхолтой лекц уншсаны зэрэгцээ ахмадуудынхаа дунд 3 насны ангилалаар АХА, Чанга шивнээ, Оюун ухааны дасгал зэрэг хөгжөөнтэй тэмцээн зохион байгууллаа.

“Зөв хэвшил-Эрүүл амьдрал” аяны хүрээнд иргэдийг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, илүүдэл жин таргалалтыг бууруулах, эрүүл идэвхтэй амьдрал, зөв дадал хэвшүүлж, эрүүл хооллолт идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих зорилготой “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” бүх нийтийн крос гүйлтийг 04 дүгээр 22-ны өдрийн Мал эмнэлгийн газар, Өсөх дэлгэр ундрах, 2-р бүрэн дунд сургуультай хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 24 аж ахуйн нэгж, иргэн, албан байгууллагын 470 гаруй хүн хамрагдаж гүйлт, алхалт, дугуй унах, дасгал хөдөлгөөн хийж оролцсон ба 4 байгууллага нийт 450,000 төгрөгийн витаминаар витаминжуулсан.

Сүрьеэ, БЗХӨ-ний илрүүлэлтийг эрчимжүүлэх хүн амын дунд идэвхтэй тандалт хийн эмчилгээнд хамруулж, хяналтад авах, зорилтот бүлгийн хүн амын судалгааг гаргах ажлыг зохион байгууллаа. Үзлэг шинжилгээнд 339 иргэн хамрагдаж 1 өвчлөл илэрсэн.

Энэрэлт ачтан, Энхлэн ачтан өрхийн эрүүл мэндийн төвүүдэд орон нутгийн төсвөөр приус-20 маркийн авто машин олгосон.

Баруун-Урт сумын 7-р багийн аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн санаачилга, дэмжлэгтэйгээр “Зөв хэвшил-Зөв амьдрал хөтөлбөр”, Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн хүрээнд “Эрүүл мэнд-Эрхэм баян” эрүүл мэндийн өдөрлөгийг зохион байгуулж иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл мэндийн боловсрол олгож, мэдлэг мэдээлэл өглөө. Уг ажлын хүрээнд:

Хүүхдийн амны хөндийн үзлэг, оношилгоо, эрдэсжүүлэх түрхлэг

Эрүүл мэндийн боловсрол, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх

Хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, зөвлөгөө

Дотрын эмчийн үзлэг, оношилгоо, зөвлөгөө

Цусанд сахар үзэх оношилгоо

Хэвлийн хөндийн Эхо, оношилгоо хийлээ. Арга хэмжээнд 59 хүүхэд, насанд хүрсэн



75, нийт 137 иргэн


хамрагдсан. Өдөрлөгт хүрэлцэн ирсэн хүүхдүүдэд дархлаажуулалтын багц олгон, монос эмийн сангаас эмийн зохистой хэрэглээ, эм витамин танилцуулгыг иргэдэд хийж хамтран ажиллалаа.

“Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газрын Гэр бүлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнтэй хамтран

хүчирхийлэлд өртөж байсан иргэдийн судалгааг гарган, гэрт нь очиж эргэлт хийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилсан.

Тус сумын 60 дээш настай 540 ахмадад УИХ-ын гишүүний бэлгийн багцыг гардуулсан.

Иргэдийн Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн “Эрүүл бие жаргалтай” нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Баруун-Урт сумын “Энэрэлт ачтан” Өрхийн эрүүл мэндийн төв зохион байгууллаа.



Боловсрол, соёл, хүүхэд хамгааллын чиглэлээр: 2023 оны 09 дүгээр сард 1-р ангид хамрагдах зургаан настай 637 хүүхдийн судалгааг гарган, Улсын бүртгэгч Б.Алтанзултай тулгалт хийн зөрчилтэй хүүхдийн мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч нарт нь мэдэгдэж зөрчлийг арилган ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 тоот тогтоолоор 2023 оныг “Хүүхдийн хөгжил хамгаалал”-ыг дэмжих болгон зарласан. Энэ ажлын хүрээнд Баруун-Урт сумын ИТХ-ын 2023 оны 16/06 тоот тогтоолоор сумын хэмжээнд долоо хоног бүрийн НЯМ гарагийг гэр бүлийн өдөр болгон зарласан. Уг ажлын хүрээнд цацарсан хайр гэр бүлийн өдрийн нээлтийн үйл ажиллагааг 05 дугаар сарын 14-ний өдрийн ням гарагт тэмдэглэн өнгөрүүллээ. Дээрх арга хэмжээнд Гэр бүл Хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Жаахан шарга” театр, Биеийн тамир спортын газар, Соёлын урлагийн газар зэрэг мэргэжлийн байгууллагууд хамтран ажилласан. Өдөрлөгөөр дараах арга хэмжээнүүд зохион байгуулагдсан. Үүнд:

- “Найз байя” аяны нээлт
- Хамтаар амьдрах соёл
Үндэсний хувцсаар гоёх уралдаан
- Цахим орчинд эерэг уриалга дэвшүүлье уралдаан
- Open mic
- Спорт өрөлтийн тэмцээн
- Гэр бүлийн буухиа тэмцээн
- Оюун ухааны тэмцээн
- Бийрэн бичлэг сургалт
- Хамтдаа зураг зурж сурцгаая сургалт
- Хамтдаа гар урлал хийцгээе сургалт тус тус зохион байгуулагдаж нийт 300 гаруй хүүхэд багачууд 100 гаруй гэр бүл оролцлоо.




Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Баруун-Урт сумын ИТХ, Сүхбаатар аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сумын Засаг даргын Тамгын газар, 9 дүгээр багийн ажлын албатай хамтран “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛИЙГ БҮТЭЭЦГЭЭ” үйл ажиллагааг 9 багийн ажлын алба гэр бүлээ хамруулан зохион байгууллаа. Өдөрлөг арга хэмжээнд нийт 22 гэр бүл хамрагдаж мэдээ, мэдээлэл авлаа.



Сумын Засаг даргын 2022 оны А/281 тоот захирамжаар "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл" байгуулсан. Дээрх зөвлөл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль цэцэрлэгт хамт олон дунд нь нийгэмшүүлэх, тэдний хэрэгцээ шаардлагад тулгуурлан ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зөвлөл. Тус зөвлөлийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг гаргах ажлын хүрээнд санал авах гишүүдийн хурлыг зохион байгууллаа.



Сумын Засаг дэргэдэх Хэлний салбар зөвлөл нь боловсрол төвтэй орчинд" уралдааны байгууллаа.



даргын Тамгын газрын бодлогын орон тооны бус аймгийн Насан туршийн хамтран "Эх бичиг- Цахим удирдамжийн дагуу зохион Уралдааны зорилго: Монгол

Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай / 2022-01-05 / ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ мэдээллийг крилл монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэхэд оршино. Уралдаанд төрийн 12 байгууллагын материал ирж 1 дүгээр сургууль, аймгийн Нийгмийн даатгал, Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр зэрэг газрыг амжилттай оролцлоо.

“Жаахан шаргын нутаг -2023” Монгол бичгийн уралдаан 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.

Үндэсний бичиг үсгийн баяр тохиолдож буй өдрүүдэд Сүхбаатарчууд Монгол бичгийн 10 төрлөөр өрсөлдлөө. Титэм арт академийн санаачлан эхлүүлсэн тус уралдааныг Баруун-Урт сумын ЗДТГ, Боловсрол шинжлэх ухааны газар хамтран зохион байгуулдаг бол энэ жил УИХ-ын гишүүн Жамбын Батсуурь ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон.



байгууллагын 280 албан хаагч, 11 сургуулийн 424 сурагчийн хичээнгүй бичвэр, мэргэжлийн 34 багшийн сайн туршлага, интерактив даалгавар, тайлан, 80 гаруй уран бүтээлчид бүтээлээ ирүүлсэн.

Жаахан шаргын нутаг-2023 уралдаан нь Сүхбаатар аймгийн яруу найрагчид зохиолчдын бүтээлээс сэдэвлэдэг онцлогтой бөгөөд энэ удаад Н.Доржцэрэнгийн зохиол бүтээлээр 28



Цаг үеийн асуудлаар:

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан байгалийн аюултай үзэгдэл 2023 оны 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд болж, тус суманд салхины хурд 30м/с хүрч цасан болон шороон шуурга шуурч үзэгдэх орчин хязгаарлагдан аюултай нөхцөл байдал үүссэний улмаас иргэдийн эд хөрөнгө, мал амьтан, хүрээлэн буй орчин, барилга байгууламжид их хэмжээний хохирол учирсан.Хохиролын жагсаалтыг хавсралтаар гарган аймгийн Онцгой комисст хүргүүлсэн.





Гамшгийн нөхцөл байдлыг арилгах ажилд 23 төрийн байгууллагын 263 албан хаагч ажилласан. Тайлант сарын 25-ны байдлаар бод-1168, бог-19034, төл 2536 нийт 9 багийн 22738 мал хорогдоод байна.

Сүхбаатар аймаг-Хөгжилд хамтдаа хөрөнгө оруулалтын чуулганд Баруун-Урт сум оролцож үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2014 оны 63 дугаар зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласан. Энэ ажлын хүрээнд 73 байгууллага нэгдэжмод тарьсан байна.




Санхүү, төрийн сан, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

УТХ-ийн буцаалт хүсэлт ирүүлсэн 2 аж нэгж, 5 иргэний 694.9 мянган төгрөгийн журмын дагуу шилжүүлж ажилласан.

Төрийн сангаар 8,048,922.0 мянган төгрөгийн 2940 ш гүйлгээг хянаж баталгаажуулсан.



Нийтийн эзэмшлийн талбайд камержуулалт байршуулах ажлыг сумын Засаг даргын А/251 тоот захирамж, зуны сувилал байгуулах ажил А/109, худалдааны гудамжны тохижилтын ажил А/50, камержуулалтын нэгдсэн систем байршуулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах А/114 тоот захирамжаар тус тус байгуулж үнэлгээний хороо 10 удаа хуралдаж тендерийг tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулсан.



Аймгийн Засаг даргын А/468 тоот захирамжаар эрх шилжиж ирсэн нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дээвэр засварын ажлыг одон хотхон 1,2 дугаар байр, 27 в байр, 2022 онд 1 удаа зарлаж амжилтгүй болж 2023 онд 1 удаа зарлаж гүйцэтгэгчээр Нар сар газар ХХК 167,192.9 мянган төгрөгөөр шалгарч ажлыг хүлээлгэн өгөх шатандаа явагдаж байна. Нэгдсэн систем нэвтрүүлэх камержуулалтын нэгдсэн тоног төхөөрөмж худалдан авах ажил, зуны сувилал байгуулах ажил, ундны ус нөөцлөх 1000м³, 2000м³ усан санг доторлох, битүүмжлэл сайжруулах ажлуудыг tender.mn сайтаар зарлан зохион байгуулж тендер хүлээн авах шатандаа явагдаж байна.



Хөдөө аж ауйн чиглэлээр: Баруун-Урт сумын онцгой комиссоос 4 ажлын хэсэг томилогдон малчны хотонд ажиллалаа. Засаг даргын орлогч Э.Хүрэлчулуунаар ахлуулсан ажлын хэсэг аймгийн төвөөс урд зүг Хар хошуу, Цагаан хошуу, Зараа, Чацаргана, Бор нуруу, Хар хамба, Говь, Шороот, Гавхайстай, Дөхөмийн уурхай, Буян овоо, Цоорхойн говь гэх газруудад ажиллаж "Мянган сэтгэл" хандивын аяны дэмжлэгийг малчдад үзүүллээ.

Малын сэг зэм устгах 5 ажлын хэсэг гарч, эзэнгүй малын сэг зэмийг устгалын цэгт аваачиж устгах ажил Эрдэнэ-Ус, Хөөвөр, Мандлын овоо, Шар худаг, Ухаа овоо, Хажуу булаг газруудаар хийгдэж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 7000 орчим сэг зэмийг устгалын цэгт хаяж, зайлуулаад байна.

"Үйлчилгээний соёлыг бид түгээнэ" сарын аяны арга хэмжээний хүрээнд Полиси төвийн захирал Г.Эрдэнэгэрэлтэй



хамтран сонирхолтой сургалт зохион байгуулагдлаа. Сургалтад 51 иргэн хамрагдлаа.

Баруун-Урт сумын хоршоо хөгжүүлэх сангаас 11 иргэн, ААНэгжид 380 сая төгрөгний зээл олголоо.

ХХААХҮЯамны сайдын А/361 тоот тушаалаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын хэрэгжилтийг хангаж Сумын ИТХ-аас тогтоосон товын дагуу хоршоо болон жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 08:30 цагаас өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдрийн 08:30 цаг хүртэл хүлээн авсан.

Тогтоосон товын хугацаанд иргэн, аж ахуй нэгжээс 33 төсөл ирүүлсэн бөгөөд төсөл сонгон шалгаруулах зөвлөл 04 сарын 25-аас-29-ний өдрүүдэд 3 үе шаттай хуралдлаа.

Нэгдүгээр шат: Дүн шинжилгээ хийх :

1. Баруун-Урт сумын иргэн, ААНэгж, хоршоо эсэх
2. Сумын тэргүүлэх чиглэлд нийцсэн эсэх,
3. Санхүүгийн тооцоолол бодитой эсэх,
4. Монгол банкны мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх
5. Шүүхийн шийдвэр, татвар зэрэг холбогдох газрын лавлагаа
6. Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй эсэх
7. Төслийн хүрэх үр дүн, зорилт тодорхой
8. Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн эсэх

Хоёрдугаар шатанд шалгарсан төсөл хэрэгжүүлэгчийн бодит нөхцөл байдалтай газар дээр нь очин танилцаж, шинжилгээ хийсэн.

Гуравдугаар шатанд төсөл хэрэгжүүлэгч төсөл сонгон шалгаруулах зөвлөлд өөрийн төслийг танилцуулсан.

ХХААХҮЯамны сайдын А/361 тоот тушаалаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын шаардлагыг хангасан дараах төслүүд дэмжигдэж 380 сая төгрөгийн зээл авлаа.

1. М.Төрбаяр - Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй- 40,000,000
2. Х.Хатанбаатар - “Аргалын утаат борц” Мах махан бүтээгдэхүүн боловсруулах - 40,000,000
3. Г.Өлзийтогтох – “Талыг Монгол борц” Мах махан бүтээгдэхүүн боловсруулах - 40,000,000
4. Т.Идэрбаяр - Бууз, баншны үйлдвэрлэл - 25,000,000
5. Н.Амартайван- Дарьганга хийц урлал- 15,000,000
6. С.Лхасүрэн-Модоор урлал хийх- 20,000,000
7. Л.Эрдэнэдалай - Модны үйлдвэрлэлийн өргөтгөл- 40,000,000
8. Б.Содхүү - Тавилга үйлдвэрлэл - 40,000,000
9. Наран булаг принт ХХК /Ц.Үүрцайх/ – “Сайран хөлт” оймс үйлдвэрлэл 40,000,000
10. “Цагаан хүч” ХХК /М.Мөнхтулга/ - Шүдний эмнэлэг тоног төхөөрөмж - 40,000,000
11. “Дөхөм өндөр” ХХК /Д.Ням/ -Металл цонх үйлдвэрлэл-40,000,000

Дашрамд дурдахад :

Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл:

- Зээлийн зориулалт: Үндсэн хөрөнгө оруулалт

- Зээлийн хугацаа: 5 хүртэл жил

- Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: 12 хүртэл сар

- Зээлийн хүү: 3 хувь

ЗЭЭЛ ОЛГОХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

* 1.Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрлэл

* 2. Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр;

- * 3. Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- * 4. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэлт
- * 5. Ноос, ноолуур угаах үйлдвэрлэл
- * 6. Малын тэжээл тариалалт, үйлдвэрлэл
- * 7. Арьс, шир дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл
- * 8. Барилгын материал үйлдвэрлэл
- * 9. Нийтийн ахуйн үйлчилгээ
- * 10. Хог хаягдал хоёрдогч түүхий эд дахин боловсруулах үйлдвэрлэл
- * 11. Аялал жуулчлал
- * 12. Орон нутагт хэрэгцээт, шинэлэг дэвшилтэд техник, технологи үйлчилгээ, үйлдвэрлэл.



Баруун-Урт сумын малчдын нутаглаж буй Сүхбаатар сум Уртын голын эх, Уулбаян сумын Хөөвөр, Мөнххаан сумын Наран сарангийн тал зэрэг нутагт үлийн цагаан оготно ихээр тархсан нийт 3000 га талбайд сумын Засаг даргын 2023 оны А/125 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдож 05-р сарын 08-ны өдрөөс 05-р сарын 11-ны өдрийн хугацаанд устгалын ажлыг зохион байгуулсан.

Устгалын ажилд Тамгын газрын 3 албан хаагч, сумын Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн аврах бүлгийн 15 албан хаагч,



малчдын төлөөлөл 25 иргэн, тээврийн хэрэгсэл 3 дайчлагдан ажиллаж, аймгийн ХХААГазраас олгосон 2,1 тн хордуулсан будаа хорыг цацсан.

Сүхбаатар сумын 4-р багийн нутаг “Хүүхдийн худаг ” гэх газар нутаглаж буй Баруун-Урт сумын 8-р багийн малчин М.Ганбатын сууриас гоц халдварт хонины цэцэг /A040/ өвчний сэжиг бүхий дуудлага ирсэний дагуу Аймгийн мал эмнэлгийн газар, Баруун-Урт сумын мал эмнэлгийн тасагт чиглэл өгч тухайн хот айлын мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийх, мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хяналтандаа авах, хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, өдөр тутмын халдваргүйтгэл хийх, өвчний шинж тэмдэгтэй малаас лабораторийн шинжилгээнд дээж материал арга зүйн дагуу авч ажиллахыг баг хариуцсан “Гүн Гуу” ББН-ний мал эмнэлгийн эмч Ч.Оюунчимэгт үүрэг өгсөн.

Гүн Гуу мал эмнэлгийн эмч Ч.Оюунчимэг, МЭГ-ийн их эмч Батбаяр нар хөдөлмөр хамгаалалын дэглэмийг сахиж, малчнаас нь тархвар зүйн судалгаа авч, өвчний шинж тэмдэг бүхий-3 хурга байснаас 1-хургыг зориудын устгалд хамруулж стандарт арга зүйн дагуу шинжилгээний дээж авч Мал эмнэлгийн газрын лабораторид хүргүүлсэн. Үзлэгээр шинж тэмдэгтэй хурга нь нүд нуухадсан, 40-41⁰С халуурсан, номойрсон, толгой хавдсан, нимгэн арьстай хэсэгт гүвдрүү, цэврүү үүссэн шинж тэмдэгтэй байсан.



Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 23-3195 тоот шинжилгээний хариугаар хонины цэцэг өвчний үүсгэгч илэрсэн. Үүний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн сумын Засаг даргын А/118 тоот захирамжаар хорио цээрийн дэглэмийг тогтоон ажилласан.

Мөнххаан сумын 1 дүгээр багийн нутаг “Бургастай” “Бортын” хоолойд гэх газар нутагладаг 8-р багийн малчин Д.Болдбаатар, Г.Отгонзоригт дуудлага ирсний дагуу баг хариуцсан “Ихэр-Жим” мал эмнэлгийн эмч Г.Гантогтох 16 цагт очиж дуудлагын дагуу хонинд үзлэг хийсэн. Үзлэгээр хонины цэцэг өвчний шинж тэмдэгтэй 12 хургыг ялган тусгаарлан, 1 хурганд задлан хийн шинжилгээний дээж материалыг арга зүйн дагуу авч Аймгийн мал эмнэлгийн лабораторид дээжийг хүргүүлэн ажилласан. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 05 дүгээр сарын 04-ны өдрийн 23-3389 тоот шинжилгээний хариугаар хонины цэцэг өвчний үүсгэгч илэрсэн.

2023 оны 05 дүгээр сарын 05-ны өдрийн Мөнххаан сумын Засаг даргын А/73 тоот захирамжийг гарган Бургастай гэх газарт хорио цээрийн дэглэмийг тогтоосон.

Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн А/145 тоот захирамжаар Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэхэд шаардагдах хөрөнгийн зардлыг гамшгаас хамгаалах сангаас нийт-4,135,700төг-ийг шийдэж өгсөн.

Гоц халдварт хонины цэцэг өвчинтэй тэмцэхэд шаардагдах зардлыг сумын Засаг даргын А/118 тоот захирамжаар Хүүхдийн худгийн голомт болон хөдөлгөөнт постод ажилласан албан хаагчийн томилолт зардлыг гамшгаас хамгаалах сангаас нийт-2,973,800 төг –ийг шийдсэн.

Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 04.27-ны 02 дугаар тушаалаар батлагдсан малын гоц халдварт өвчний үед шалган нэвтрүүлэх цэгийн ажиллах зааврын дагуу Сүхбаатар сумын “Хүүхдийн худаг” гэдэг газарт гоц халдварт хонины цэцэг өвчинтэй холбогдуулан хөдөлгөөнт постод 8-н хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч, Аймгийн Онцгой байдлын газрын ахлах ахлагч Ж.Доржсүрэн, Цагдаагийн газрын дэд ахлагч Б.Отгонбаатар, ЗДТГазраас мэргэжилтэн 72 цагаар ээлж солигдон орох, гарах машины хөдөлгөөнийг зохицуулалт хийн бүртгэн, малчдад болон мал бүхий иргэдэд заавар зөвлөмжийг өгч, орсон гарсан нийт-225



машины дугуйг-2250 м² ариутгал халдваргүйтгэлийг хийж, малын гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавин холбогдох бичиг баримтыг шалган нэвтрүүлэн ажиллалаа.

Голомтод ажиллаж буй 2 малын эмч нь өдөр бүр мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийж, халдваргүйтгэлийг тогтмол хийж байна. Голомтод болон сэжигтэй бүсэд байгаа малчин өрхийн 14454 толгой малд эрүүл мэндийн үзлэг хийж, өвчний шинж тэмдэгтэй 3 -н хургыг зориудын устгалд хамруулан, үхсэн -43 хургыг устган ариутгал халдваргүйтгэлийг хийн ажилласан.

Голомттой бүсийн ариутгалд -15000 м², сэжигтэй бүс-25300 м² халдваргүйтгэлийг хийн ажиллалаа.

2023 оны 05 дүгээр сарын 16- ны өдрийн сумын Засаг даргын А/148 тоот захирамжаар “Хүүхдийн худаг ” гэх газрын хорио цээрийн дэглэмийг бууруулан хязгаарлалтын дэглэмд



шилжүүлсэн.

МЭГазраас цэцгийн вакцин -11,7 мян/ тун вакциныг авч, голомт болон сэжигтэй бүсийн малыг вакцинжуулахад Гүн-Гуу мал эмнэлэг 16 өрхийн хонь-5995, хурга-2660 нийт-8655 толгой малд, Ихэр-Жим МЭ- 2 өрхийн хонь-1228, хурга-264 нийт-1492 нийт-10147 толгой малд вакцинжуулалтыг хийсэн.

Хонины цэцэг өвчний голомттой болон сэжигтэй малчин өрхийн судалгааг гарган МЭГазарт хүргүүлсэн.

МЭГазраас нэмэлт цэцгийн вакцин-28,0 мян/тун хүлээн авч, Гүн-Гуу мал эмнэлэгт-10,0 тун, Ихэр-Жим мал эмнэлэгт-10,0 тун, Жавхлант-Өлзийт мал эмнэлэгт-8,0 тун хуваарилан өгч ажилласан.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах үхэр, гахайны судалгааг гарган МЭГазарт хүргүүлэн ажиллалаа.

Шүлхий вакцинжуулалт хийхтэй холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дүгээр сарын 03-ны өдрийн А/128 тоот захирамж гарч, сумын гамшгаас хамгаалах нөөц сангаас бензинд-4,995,300 төг, туслах ажилчин-3,000,000 төг нийт- 7,995,300 төг-ний зардал тооцоог шийдсэн. Сумын хэмжээний үхэр-46262 толгой мал, гахайг -132 шүлхий дархлаажуулалтад хамруулахаар Мал эмнэлгийн газраас шүлхий вакцин-46.4 мян/тун хүлээн авч, ААН-6 мал эмнэлгийн малын эмч нарт хуваариалан өгч ажилласан.

Шүлхий вакцинжуулалтын явцын мэдээгээр үхэр-5380, гахай-32 нийт-5412 толгой малд вакциныг хийгээд байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/51 тоот тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тоот албан даалгаварын ажлын хүрээнд сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны А/48 тоот захирамж гарч, Засаг даргын нөөц сангаас сэг зэм устгал, халдваргүйтгэл хийхэд шаардагдах зардалд-3205900 төг-ийг шийдвэрлэсэн.

Хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон малын сэг зэмийг устгах, бэлчээр бууц хашаа байр, нийтийн эзэмшлийн гудамж талбайд цэвэрлэгээ халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх халдваргүйтгэл хийгдэж байна.

2023 оны 05 дугаар сарын 10- ны явцын мэдээгээр мал амьтны сэг зэмийн устгалд: адуу-50, үхэр-87, хонь-540, ямаа-412, бусад амьтны-235 нийт-1324ш сэг зэмийг цуглуулан хогийн нэгдсэн цэгт төвлөрлүүлэн хаяж,хашаа хороо-14.8 м²,өтөг бууц-6.5 м² худаг уст цэгт-1.8 м², агуулах зоорь-5.5 м², нийтийн эзэмшлийн-5.6 м²,устгалын цэг-3.0 м² бэлчээрийн-10.2 м² талбайд нийт-47,4м² халдваргүйтгэлийг хийгээд байна.

Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги: Асгат руу гардаг замын баруун талын



модны хамгааллын торыг засч янзлан шинээр тор татсан.

Төв талбайн зүүн талын сааданд 35 голт бор тарьж хаврын нөхөн тарилт хийлээ.

Жил бүрийн 5 дугаар сарын 2 дахь 7 хоногт нийтээр мод тарих өдөр байгууллагуудын тарьсан модыг услаж, мод тарих, арчлах талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.



Амгалан хошуун дахь мод үржүүлгийн талбайн газраа хагалуулж, мод тарихад бэлэн болголоо.

5 дугаар сарын 10-11-ны өдрүүдэд төв талбай дээр



зохион байгуулагдсан
“Тарьц, суулгацны
үзэсгэлэн” худалдаанд
оролцон мод тарих, арчлах,

хамгаалах талаар болон багаж, хайч бусад хэрэгслийн талаар үзүүлэн бэлтгэж зөвлөгөө өгөн оролцсон.

Хувиарт тойргуудын усалгаа болон төвийн саад, хуучин наадмын талбайн модонд усалгаа, арчилгааг тогтмол хийж байна.

Голын эхээс 4 удаа бууц татаж Амгалан хошуун дахь талбайд асгаж мод тарих хөрсийг



бэлтгэсэн.

Мод үржүүлгийн талбайд болон хүлэмжинд үрээр тарих талбайг бэлтгэн засч, агч, буйлс, гүйлс зэргийг үрээр үрсэлгээ хийж тарьлаа.



Хог хаягдлын чиглэлээр:

Баруун-Урт сумын гэр хорооллын хог ачилт батлагдсан хуваарын дагуу 1,2,3,4,5,6,9 багуудын гэрээт 1742 айл өрхөөс хог тээврийн жолооч 4 хог тээврийн ачигч 6, ковш жолооч 1 нийт 11 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж 235 удаагийн ресийн 1340 тонн хог хаягдалыг төвлөрсөн хогын нэгдсэн цэгт, мөн төвийн орон сууцны 2243 айл өрх болон



ашиглалтад орсон 2-р



гэрээт 170 аж ахуй нэгжээс жолооч 2 ачигч 4 нийт 6 хүний бүрэлдхүүнтэйгээр 97 удаагийн ресээр 952 тонн хог хаягдал, төвийн ангилан ялгах хогийн савнаас 41 удаагийн ресээр 82 тонн хог хаягдал нийт 2374 тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэн шинээр зэргийн хяналттай хогийн цэгт

буулгаж 50 ковшоор 4 удаагийн түрэлт хийж хог хаягдлыг дарж булшилсан.

Аюултай хог хаягдал

Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг болон аюултай хог хаягдлын гэрээт 10 аж ахуй нэгжээс хог хаягдлын хувиар маршрутын дагуу 2173,5кг аюултай хог хаягдлыг жолооч 1 ачигч 1 нийт 2 хүний бүрэлдхүүнтэй авч аюултай хог хаягдлыг шатаах зууханд хийж устгалаа.



Сүхбаатар аймгийн Засаг даргын 2019 оны А/247 тоот “Аймгийн төвөөс мал гаргах” захирамжийн дагуу өдөр бүр малыг хотын төвөөс гаргах ажлыг зохион байгуулж хотын төвд орж ирсэн малыг байгууллагын мал түр хаших хашаанд хаших, гаргах зэрэг ажлыг жолооч, мал хөөгч гэсэн 2 хүн өдөр тутамдаа тогтмол ажиллаж байна.12 үхэрийг хашиж малчин эзэнтэй холбоглож Баруун-Урт сумын ЗДТГ-ын мэргэжилтэн болон Аймгийн цагдаагын газрын зөвшөөрлийн бичгийг үндэслэн эзэнд нь хүлээлгэн өгсөн. Мөн сумын төв болон ногоон байгууламжийн бүсэд орж ирсэн 32 адуу 98 үхэр хөөж ногоон бүсээс гаргалаа.



Манай тасаг нь дарга-1, жолооч-1, зам талбайн үйлчлэгч-16. (эрэгтэй 5, эмэгтэй 13) нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй Баруун-Урт сумын хэмжээнд хатуу хучилттай авто зам 53.4 км, явган хүний зам 52048 м2, хариуцан ажиллаж байна. Үүнд :

- Нийтийн эзэмшлийн явган болон авто зам
- Үерийн далан суваг 3,5км
- Эзэнгүй хог, сэг зэм
- Цэцэрлэгт хүрээлэн хөшөө дурсгал 24, тоглоомын талбай 24
- Шарилж устгал
- Замын тэмдэг засвар үйлчилгээ
- 3, 4, 5-р тойргын зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан иргэдийг хоггүй цэвэр эрүүл орчинд аятай тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.

Тоглоомын талбайн засвар хийгдэж байна.



Үер далан, суваг авто замын цэвэрлэгээ хийгдлээ.



Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээг 3,4,5-р тойргийн дагуу хийлээ.



Золбин нохой устгах ажлыг 7 хоног бүрийн даваа, лхагва, баасан гаригт зохион байгуулж байна.Тайлант сарын байдлаар нийт **150** золбин нохой устгалаа.



Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг болон аюултай хог хаягдлын гэрээт 10 аж ахуй нэгжээс хог хаягдлын хувиар маршрутын дагуу 2173,5кг аюултай хог хаягдлыг жолооч 1 ачигч 1 нийт 2 хүний бүрэлдхүүнтэй авч / Аюултай хог хаягдлыг шатаах зууханд / хийж устгалаа.



Манай байгууллага нь Сүхбаатар аймгийн Засаг даргын 2019 оны А/247 тоот “Аймгийн төвөөс мал гаргах” захирамжийн дагуу өдөр бүр малыг хотын төвөөс гаргах ажлыг зохион байгуулж хотын төвд орж ирсэн малыг байгууллагын мал түр хаших хашаанд хаших, гаргах зэрэг ажлыг жолооч, мал хөөгч гэсэн 2 хүн өдөр тутамдаа тогтмол ажиллаж байна. 12 үхэрийг хашиж малчин эзэнтэй холбоглож Баруун-Урт сумын ЗДТГ-ын мэргэжилтэн болон Аймгийн цагдаагын газрын зөвшөөрлийн бичгийг үндэслэн эзэнд нь хүлээлгэн өгсөн. Мөн сумын төв болон ногоон байгууламжийн бүсэд орж ирсэн 32 адуу 98 үхэр хөөж ногоон бүсээс гаргалаа.



МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

А.ӨЛЗИЙЖАРГАЛ